1

# "ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Төлөвлөгөөг баталсан:* **Төсвийн шууд захирагч**

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД .................................... Н.УЧРАЛ

.....IV/6 2023.....
(огноо)

*Төлөвлөгөөг боловсруулсан:* **Төсвийн шууд захирагч**

"ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УТҮГ ЗАХИРАЛ .................................... М.БАТТУЛГА

.....2023.01.09.....
(огноо)

9020011093 5323304

Албан хэрэгцээнд

# "ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр

Улаанбаатар хот

| д/д | Хөтөлбөр *(зорилтын нэр)*, хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | | Хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шалгуур үзүүлэлт */тоо, чанар/* | Суурь түвшин | Зорилтот түвшин | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 1 | 2 | 3 |

**ЗОРИЛТ 1. БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ, СУУРЬ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

**Стратеги 1. Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1 | Төвийн Стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах арга хэмжээ авах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх;<br>б/ Салбарын бодлого төлөвлөлттэй уялдуулсан байх;<br>в/ Өмнөх стратеги төлөвлөгөөний биелэлт, үр дүнг гаргаж, судалгаа хийж байгууллагын стратегийн зорилтыг бүрэн тодорхойлсон байх; | Үндэсний дата төвийн 2024 он хүртэлх Стратеги төлөвлөгөөний төслийг бэлтгэсэн. Үндэсний дата төвийн дүрэм, бүтэц шинэчлэн батлагдахтай холбоотойгоор хүлээгдсэн. | Байгууллагын 2023-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулж, удирдах дээд байгууллагад хүргүүлсэн байна. | 1 улиралд | ЗУГ /ТЗХ/ |
| 1.1.2 | Төвийн 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг тогтсон хугацаанд удирдах дээд байгууллагад хүргүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Төвийн үйл ажиллагааг жилээр төлөвлөж, улирал, хагас жил, жилээр тайлагнасан байх;<br>б/ Үйл ажиллагааны төлөвлөгөө нь удирдах дээд байгууллагын үйл ажиллагаатай уялдсан байх; | Байгууллагын үйл ажиллагааны улирал, хагас жил, жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулан удирдах байгууллагад хүргүүлсэн. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлсэн. | Үйл ажиллагааны явцын талаар удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан байна. | Улирал бүр | ЗУГ /ТЗХ/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | в/ Үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг баримталсан байх; | | | | |
| 1.1.3 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.3-д заасан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:27001 стандартыг нэвтрүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:27001 стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай журмуудыг шинэчлэх;<br>б/ Мэдээллийн аюулгүй байдлыг удирдлагын тогтолцоо ISO:27001 стандартыг нэвтрүүлэлтийн түвшинд хяналт тавьж, сургалт мэдээлэл тогтмол хийх; | Монгол улсын стандарт MNS ISO/IEC 27001:2013 нэвтрүүлэхтэй холбоотой 10 журам үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Холбогдох ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан. | Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:27001 стандартын шаардлагыг бүрэн хангаж гэрчилгээ авсан байна. | Жилд | Бүх нэгж |
| 1.1.4 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах судалгаа хийж, үр дүнд үндэслэн хэлтэс хоорондын уялдаа холбоо, дотоод үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах судалгаа хийх;<br>б/ Үндэсний дата төвийн үйл ажиллагааны шат дамжлага, дэс дараалын баримт бичигт үндэслэн хэлтэс хоорондын уялдаа холбоог сайжруулсан байх;<br>в/ Төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"–ын дагуу зохион байгуулах; | Байгууллагын болон хэлтэс хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, хяналт шалгалтын үр дүн зөвлөмж өгч ажилласан. | Байгууллагын дотоод үйл ажиллагааг оновчтой зохион байгуулалтаар хангаж, дотоод хяналт шалгалтыг хийж, үйл ажиллагааны шат дамжлага, дэс дараалын баримт бичигт үндэслэн хэлтэс хоорондын уялдаа холбоог сайжруулж ажилласан байна. | Жилд | ЗУГ<br>/ТЗХ/ |
| 1.1.5 | Байгууллагын бүтэц, орон тоо зохион байгуулалтын чиг үүргийг шинэчлэн боловсруулж, | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Холбогдох хууль тогтоомжид тусгагдсан үүрэг чиглэл бүрэн тусгагдсан байх; | Холбогдох хуулиуд болон удирдах дээд байгууллагын чиг үүрэгтэй уялдуулан | Өөрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, | 1 улиралд | ЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах арга хэмжээ авах | | б/ Удирдах дээд байгууллагын бодлого төлөвлөлтөд нийцсэн байх;<br>в/ Өөрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтцийг шинэчлэн зохион байгуулсан байх;<br>г/ Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх; | бүтэц орон тоог шинэчлэн батлуулахаар яаманд хүргүүлсэн. | орон тоо зохион байгуулалтын чиг үүргийг оновчтой хуваарилсан байна. | | |
| 1.1.6 | Нийтийн мэдээллийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, мөрдөж ажиллах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Холбогдох хууль тогтоомжид тусгагдсан үүрэг чиглэлийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэх;<br>б/ Өөрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай шинэчлэлтийг зохион байгуулсан байх;<br>в/ Холбогдох хуулийн хэрэгжилттэй холбогдуулан үйлчилгээний хүрээнд төрийн болон бусад байгууллагад зөвлөмж өгч ажилласан байх; | Төвийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой шинэчлэгдсэн хуулиудын хэрэгжилтийг байгууллагаас зүгээс хангаж ажилласан. | Төвийн үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээнд шинэчлэн батлагдсан, шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажилласан байна. | Жилд | ЗУГ |
| 1.1.7 | Төвийн хэмжээнд мөрдөгдөх шаардлагатай эрх зүйн баримт бичгийг боловсруулж батлуулах, зарим журам, заавар, зааварчилгааг нэгтгэх, сайжруулах | Дотоод нөөц | **Тоо: 1**<br>**Чанар:** а/ Шинээр батлагдсан хууль, тогтоол, журамд нийцүүлэн дотоод журам шинэчлэн баталсан байх;<br>б/ Төвийн хэмжээнд мөрдөгдөж буй журам зааврыг нэгтгэж, сайжруулах, шинээр боловсруулсан байх;<br>в/ Үр дүнг үнэлэх, шилдэг ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлж журмаар тодорхой болгосон байх; | Үйл ажиллагаандаа 38 төрлийн журам, заавар мөрдөж ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн тухай шинэчилсэн найруулгад нийцүүлэн байгууллагын дотоод журам болон хөдөлмөрийн гэрээг шинэчлэх бэлтгэл ажил хангасан. | Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэж, мөн мөрдөгдөж буй дүрэм, журмуудын зохицуулалт, уялдаа холбоо сайжруулж төвийн ажилчдын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 1 улирал | ЗУГ |

4

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | г/ ОУ–ын сертификат эзэмшигчид олгох урамшууллыг журамд тусгасан байх, олгох тусгай хөтөлбөртэй байх; | | | | |
| 1.1.8 | Төвийн "Хүний нөөцийн бодлого" -ыг хэрэгжүүлэх, технологийн мэргэжилтний нөөцийг бэлтгэх | Дотоод нөөц | **Тоо: 1**<br>**Чанар:** а/ Мэргэшлийн ангид суралцагч оюутны анкет бүртгэлтэй болсон байх;<br>б/ Хүний нөөцийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө, календарчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах;<br>в/ Үйл ажиллагаа, хэлтэс, ажилтан хоорондын уялдаа холбоог сайжруулах судалгаа хийх, арга хэмжээ авч ажиллах;<br>г/ Ажлын байр, өрөө танхимын зохистой орчныг бий болгох чиглэлийг баримталсан байх;<br>д/ Төвийн нийт ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Мэргэжлийн сургуультай санамж бичиг байгуулж, сургалт өдөрлөгт оролцож анкет бүрдүүлж ажилласан.<br>Идэвхжүүлэлтийн төлөвлөгөө гаргасан.<br>Ажилтнуудын ажиллах таатай орчныг бий болгох зорилгоор өрөө танхимын засвар, тохижуулалтын ажлууд хийгдсэн. | Хүний нөөцийн тогтвортой байдал, бэлэн байдлыг хангах чиглэлээр тогтмол арга хэмжээ авч ажиллана. | Жилд | ЗУГ |
| 1.1.9 | "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах | Дотоод нөөц | **Тоо: 1**<br>**Чанар:** а/ Сургалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, Батлагдсан төсвийн хүрээнд хариуцан ажиллаж буй ажлын чиг үүргийн дагуу мэргэшүүлэхэд чиглэгдсэн байх;<br>б/ Хүний нөөцийг хөгжүүлэх дотоод үйл ажиллагааны чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулах, байгууллагын ажлын зохион байгуулалт, удирдахуйн чиглэлээр сургалт авах; | Мэргэжлийн 31 инженер техникийн ажилтнууд ажиллаж байна. Үүнээс 65%-нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтад хамрагдсан сертификаттай ажилтнууд байна. | Байгууллагын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн 70 хувь нь сургалтад хамрагдсан сертификаттай, ажиллахад таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Жилд | ЗУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | в/ Хүний нөөцийг сэлгэн ажиллуулах, зайнаас ажиллах, ажилтнуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх; | | | | |
| 1.1.10 | Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төвийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, ил тод нээлттэй байдлаар журмын дагуу явуулсан байх | Дотоод нөөц | **Тоо: 1**<br>**Чанар:** а/ Хуулийн дагуу 2023 оны худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байх;<br>б/ Үнэн зөв, ил тод байдлаар мэдээлсэн байх;<br>в/ Хуулийн дагуу төлөвлөсөн хугацаанд багтаан 2024 оны төвийн үйл ажиллагааны нийт төсвийг хамруулсан төлөвлөгөө боловсруулсан байх;<br>г/ Холбогдох байгууллагуудад худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүргүүлэн ажилласан байх; | 2022 оны худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан.<br>2023 оны төсөв, хөрөнгө оруулалтын саналыг удирдах дээд байгууллагад хүргүүлсэн. | Худалдан авалтыг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулж, тайлагнасан байна. Тус төвд хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бараа, ажил, үйлчилгээний талаарх мэдээллээр удирдах дээд байгууллагыг хангаж ажилласан байна. | Жилд | ЗУГ<br>/ТЗХ/ |
| 1.1.11 | Төвийн санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, жилийн тайлан балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх | Дотоод нөөц | **Тоо: 1**<br>**Чанар:** а/ Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг баримтлан хуулийн хугацаанд гүйцэтгэсэн байх;<br>б/ Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилласан байх;<br>в/ Аудитын байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байх;<br>г/ Эд хөрөнгийн тооллогыг хагас жил тутамд гүйцэтгэх; | Байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд зохион байгуулж, 2022 оны баримтыг журмын дагуу бүрдүүлж ажилласан. Санхүүгийн үйл ажиллагааны 2021 оны дүгнэлтийг гаргуулсан байна. | Төвийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагааны талаарх үнэн, бодит мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангаж ажилласан байна. | Жилд | ЗУГ |

**Стратеги 2. Хамтын ажиллагааг хөгжүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.1 | Төвийн гадаад мэдээ, мэдээлэл, сурталчилгааны бодлогыг тогтмол хэрэгжүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Салбарын олон нийтийн хамарсан арга хэмжээ, мэдээ, мэдээлэлтэй уялдуулан байгууллагаас хийгдсэн ажлуудаа нийтэд тогтмол мэдээлж ажиллах;<br>б/ Сурталчилгааны олон талт сувгуудыг ашиглаж, постер, видео, танилцуулга хэлбэрээр цацсан байх;<br>в/ Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулах арга хэмжээ авах;<br>г/ Нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байх; | Тус төвөөс олон нийтэд чиглэсэн таниулан сурталчлах ажлыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. Ерөнхий байгууллагын танилцуулга англи монгол хэл дээр бэлтгэсэн. Байгууллагын нийтийн сүлжээг тогтмол хөтөлж, мэдээ, мэдээлэл нийтэлж ажилласан. | Төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан, сурталчилсан байна. | Жилд | ЗУГ, МТГ |
| 1.2.2 | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ 2 -оос доошгүй байгууллагатай хамтран ажилласан байх;<br>б/ Олон улсад зохион байгуулагдах салбарын 2 -оос доошгүй арга хэмжээнд оролцсон байх;<br>в/ Төрийн байгууллага болон дотоод, гадаадын компанийн аюулгүй байдлын багтай хамтарч, халдлагын мэдээлэл авах, илгээх, шинжлүүлэх зэрэг харилцан туршлага солилцох, хамтран ажиллах; | БНСУ -д болсон арга хэмжээнд оролцсон. Бусад шаардлагатай арга хэмжээг судалж ажилласан.<br>Төсөвтэй холбоотойгоор зарим арга хэмжээ хойшлогдсон. | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан байна. | Жилд | ЗУГ, МАБГ |
| 1.2.3 | | | **Тоо:** 2 | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн болон бусад холбогдох байгууллагуудын мэргэжилтэн, удирдлагуудыг хамруулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулах, тэдгээрт оролцох | Дотоод нөөц | **Чанар:** а/ Төрийн байгууллагуудыг хамруулсан мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, мэдээллийн аюулгүй байдлын сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>б/ Салбарын экспо, ойн арга хэмжээнд оролцсон байх;<br>в/ Бусад холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулах, оролцох; | "Цахим үндэстэн" арга хэмжээ зохион байгуулахад оролцсон. "Cloud infra day" сургалт арга хэмжээг "Фибо клауд" ХХК -тай хамтран зохион байгуулахад оролцсон. | Төрийн болон салбарын байгууллагуудын хүрээнд мэдээллийн технологи, аюулгүй байдлын талаарх нэгдмэл ойлголт, мэдээллийг бий болгосон байна. | Жилд | ЗУГ, МАБГ, МТГ |
| 1.2.4 | Удирдах дээд шатны байгууллагуудаас байгуулагдаж буй ажлын хэсгүүдэд хамрагдах хэлбэрээр хамтран ажиллах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Ажлын хэсгийн хурлуудад оролцож байгууллагын санал, дүгнэлтийг хүргүүлж ажилласан байх; | Удирдах дээд 3 байгууллагын 6 үндсэн болон дэд ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд холбогдох баримт бичгийн төсөл санал, мэдээлэл хүргүүлсэн. | Холбогдох ажлын хэсгүүдэд хамрагдан байгууллагын зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлсэн байна. | Жилд | ЗУГ, МАБГ, МТГ |
| 1.2.5 | Салбарын хэмжээнд боловсруулагдаж буй хууль, эрх зүй, бодлогын баримт бичиг, стандартуудад санал өгөх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Ирүүлсэн албан тоотын хүрээнд өөрийн байгууллагын саналыг хүргүүлсэн байх;<br>б/ Салбарын хэмжээнд боловсруулагдах хууль, эрх зүйн баримт бичгийн төслүүдэд санал өгсөн байх; | Үндсэн систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журмын төсөл, үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, "Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал" -ийн санал хүргүүлсэн. | Салбарын хэмжээнд боловсруулагдаж буй хууль, эрх зүй, бодлогын баримт бичигт байгууллагын санал, дүгнэлтийг хүргүүлсэн байна. | Жилд | ЗУГ |
| 1.2.6 | Төрийн байгууллагуудад үйл ажиллагаа, үйлчилгээг | | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Тухайн байгууллагын үйл ажиллагааг хөнгөвчилж, зардлыг бууруулахад чиглэгдсэн байх; | Төрийн хамгаалалт бүхий барилга байгууламжийн нэвтрэлт бүртгэлийн систем, | Төрийн байгууллагуудад үйл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахимжуулахад дэмжлэг үзүүлэх | Дотоод нөөц | б/ Төрийн байгууллагын сервер, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт боловсруулах нийтлэг шаардлага боловсруулах;<br>в/ МУ -ын Засгийн Газрын "mongolia.gov.mn" цахим хуудас, ТТХГ –ын "epass" болон бусад системд сайжруулалт хийсэн байх; | Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын "licemed.gov.mn" хөгжүүлэлтийг хийж ХУР системд оруулсан.<br>МУ -ын Засгийн Газрын mongolia.gov.mn цахим хуудсыг хариуцан ажилласан. | ажиллагааг хөнгөвчилж үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна. | Жилд | МТГ |
| 1.2.7 | МУЗГ -аас 2023 оныг Монгол Улсад зочлох жил болгон зарласантай холбогдуулан гадаадын иргэдийн цахим үйлчилгээ авах боломжийг бий болгох, технологийн орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Fregister олгох ажлыг автоматжуулах;<br>б/ И-Монгол цахим порталд гадаад иргэдэд зориулсан үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх;<br>в/ Киоск машинуудаар гадаад иргэдийг таньсны үндсэн дээр хялбар үйлчилгээ авах боломжийг нэвтрүүлэх; | | Хил хамгаалах ерөнхий газраас гадаад иргэнийг МУ-ын хилээр нэвтрэх үед хур системээс сервис дуудах замаар Fregister олгодог болсон байна. Гадаад иргэдийн мэдээллийг эзэмшиж төрийн байгууллагуудын мэдээллийн санг Fregister-тэй холбох замаар ХУР системээс мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна. | 3 улиралд | МТГ /СНХ/ |

**Стратеги 3. Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.1 | Төвийн цахилгаан хангамжийн техник | | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа хангагдсан байх; | 2022 онд Цахилгаан хангамжийн системийн тасралтгүй ажиллагаанд хяналт | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төхөөрөмж, холболтуудыг шинэчлэх, сайжруулах | Гадны зээл тусламж | б/ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байх;<br>в/ Өндөр хүчдэлийн сэлгэн залгах төхөөрөмжийг шинээр суурилуулсан байх;<br>г/ 10кВ-ын кабель шугамыг шинээр татаж, холболтыг гүйцэтгэсэн байх;<br>д/ Нөөц төвийн үндсэн тэжээлийн холболт, туршилт хийсэн байх; | тавьж, найдвартай ажиллагааг хангасан. | Цахилгаан хангамжийн найдвартай ажиллах боломжийг бүрдүүлсэн байна. | Жилд | ЗУГ /ТАҮХ, НТХ/ |
| 1.3.2 | Төвийн дизель генераторын байгууламжийг шинэчлэн, сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Нөөц цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа хангагдсан байх;<br>б/ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байх;<br>в/ Дизель генераторын байгууламжийг шинэчлэн сайжруулсан байх; | Дизель генераторын байгууламжид урсгал засварыг гүйцэтгэж холбогдох тохиргоог тухай бүр хийж гүйцэтгэсэн. | Нөөц цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа болон бэлэн байдал хангагдсан. | Жилд | ЗУГ /ТАҮХ/ |
| 1.3.3 | Төвийн дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төвийн дэд бүтцэд байршин ажиллаж буй төхөөрөмжүүдийн зохистой ашиглалтад хяналт тавих;<br>б/ Дэд бүтцийн системийн үзлэг, үйлчилгээний хуваарийг гарган хэрэгжүүлсэн байх;<br>в/ Дэд бүтцийн системийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээг судалгааны үндсэн дээр авч хэрэгжүүлэх, үр ашиггүй ажиллаж буй төхөөрөмжүүдийг тодорхойлж гаргах;<br>г/ Байгууллагын нэвтрэлтийн системийг шинэчлэн сайжруулах; | Тус төвд байршин ажиллаж байгаа цахилгаан хангамжийн систем болон зохих техникийн үзлэг, шалгалтыг 7 хоногт 2 удаа гүйцэтгэж техник ашиглалтын паспорт, техникийн үзлэгийн дэвтэрт бүртгэн ажиллаж байна. | Дэд бүтцийн систем, сервер төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа хангаж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн нөөцийг бэлтгэсэн байна.<br>Эрчим хүчний зарцуулалтад хяналт тавьж зохицуулалт хийнэ. | Жилд | ЗУГ /ТАҮХ, НТХ/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.4 | Төвийн барилга байгууламж, гадна талбайн тохижилт, дэд бүтцийн өрөө танхимын урсгал засварын ажлыг гүйцэтгэх | Урсгал зардал | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Батлагдсан төсвийн хүрээнд үндсэн болон нөөц дата төвийн урсгал засварын ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн байх;<br>б/ Хойд худагт ажил үйлчилгээ хийх боломжтой ажлын байрыг бий болгож, ашиглалтад оруулах;<br>в/ Гадна талбайн болон дотор талын тохижилтыг хийж гүйцэтгэх; | Тус төвийн өрөө тасалгаанд шаардлагатай урсгал засварыг цаг тухай бүрд хийж, гадна талбайн тохижилтыг сайжруулж гүйцэтгэсэн байна. | Барилга байгууламж, дэд бүтцийн өрөө танхимын хэвийн ажиллагаа хангагдсан байна. | 2,3-р улиралд | ЗУГ /ТАУХ, НТХ/ |
| 1.3.5 | Хөргөлтийн төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах | Урсгал зардал | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ "МИХХ" дахь мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн ажиллах тусгай орчин сайжруулсан байх;<br>б/ Хөргөлтийн төхөөрөмжийг шинэчлэн суурилуулсан байх;<br>в/ Хөргөлтийн төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажилласан байх; | "МИХХ" -ийн төхөөрөмж байршиж буй өрөөны үзлэг үйлчилгээг хийж, техникийн үзлэгийн дэвтэрт бүртгэл хөтлөн ажилласан. | "МИХХ" дахь мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн ажиллах орчныг сайжруулж, хяналтыг тогтмол хийж ажилласан байна. | Жилд | ЗУГ /ТАУХ/ |

**Стратеги 4. Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1 | Төвийн систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглагдаж буй сервер тоног төхөөрөмж, | | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Сервер тоног төхөөрөмж, системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангасан байх;<br>б/ Физик сервер, хадгалах төхөөрөмжүүдийн "Firmware" шинэчлэл хийгдсэн байх;<br>в/ Сүлжээний тоног төхөөрөмжийн хувилбаруудыг, аюулгүй байдлын | Төрийн байгууллагын зохиомол серверийн дэд бүтцийн системийн шинэчлэлийг хийж, шилжүүлэн байршуулсан. Төрийн клауд дэд бүтцийн туршилтын орчныг бий болгон ажилласан. | | | Бүх нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системийн үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Дотоод нөөц | шаардлагын хувьд тогтмол сайжруулалт хийсэн байх;<br>г/ Серверийн өрөөний сүлжээний кабел ашиглалт зохион байгуулалтын сайжруулалт, хийсэн байх;<br>д/ Төвийн хандалтын түвшний сүлжээ болон удирдлагын сүлжээний зохион байгуулалтыг шинэчлэх;<br>е/ Үндсэн болон дэмжих системүүдийг сүлжээний хувьд физик тусгаарлалт хийх;<br>ё/ Тасалдал бүртгэх системийг сайжруулж мониторингод тогтмол хэрэглэж эхэлсэн байх;<br>ж/ Байгууллагын дуудлагын төвийн үйлчилгээг хүлээн авах системийг сайжруулах;<br>з/ Төвийн хаалганы нэвтрэлт – удирдлагын системийг оруулсан байх; | Сүлжээний тоног төхөөрөмжийн системийн сайжруулалтыг тогтмол хийж ажилласан. | Төвийн систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. | Жилд | |
| 1.4.2 | Төрийн байгууллагын цахим шуудангийн системийн ажиллагааг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Цахим шуудангийн системийн хэрэглэгчдийн мэдлэгийг сайжруулах, сургалт зохион байгуулах, гарын авлага, заавар зөвлөгөөг гаргах; | Системийг шинэчлэн, сайжруулж, 60 дэд системээс бүрдсэн цахим шуудангийн дэд бүтцийг бий болгосон. Төрийн 632 домэйн бүхий нийт 43750 цахим шуудангийн хэрэглэгчийн шууданг шинэ систем рүү шилжүүлэн байршуулсан. | Төрийн байгууллагын цахим шуудангийн хэрэглэгчдийн ашиглалт сайжирсан байна. | Жилд | МТГ |
| 1.4.3 | Байгууллагын мэдээллийн технологийн программ | | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Лицензийн хүчин төгөлдөр байх | Батлагдсан төсвийн дагуу холбогдох | Лицензтэй программ хангамж ашигладаг | | МАБГ, МТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хангамжуудын лицензийг сунгуулах | Улсын төсөв | хугацааг дуусахаас өмнө сунгуулсан байх;<br>б/ Лицензгүй программ хангамжийг төсвийн хүрээнд лицензжүүлэх чиглэлийг баримталсан байх;<br>в/ Батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлсэн байх; | худалдан авалтуудыг цаг тухай бүрд зохион байгуулсан. Төсөвтэй холбоотойгоор зарим сунгалт хийгдээгүй. | системүүд лицензийн асуудлаас шалтгаалан тасалдаагүй байна. | Жилд | |
| 1.4.4 | Төвийн хэмжээнд нөөцлөлтийг холбогдох журмын хүрээнд бүрэн гүйцэтгэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Нөөцлөлтийг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн байх;<br>б/ Шинээр ашиглалтад орох клауд дэд бүтцийн нөөцлөлт хийх боломжтой болсон байх;<br>в/ Төрийн цахим шуудангийн локал нөөцлөлтийг тогтмол хийсэн байх;<br>г/ Суурь мэдээллийн сангуудын систем нөөцлөлтийг хийж, эрсдэлийг бууруулах; | Төвийн нөөцлөлтийн тоног төхөөрөмжийн ашиглалт 30% хүрсэн бөгөөд, төрийн зохиомол серверүүд төрийн цахим шуудан, төрийн цахим хуудас байршуулах хостийн нөөцлөлтүүдийг тогтмол нөөцлөлт хийж ажилласан. Нөөцлөлтийн системээс нийт 6 удаа систем сэргээх хүсэлтийг шийдвэрлэсэн. | Эрсдэл үүссэн үед, төвийн үйлчилгээний үндсэн системүүдийг нөөцлөлтөөс сэргээх боломжийг бүрдүүлж, нөөцлөлтийн журамд нийцүүлж, ажилласан байна. | Жилд | МТГ |
| 1.4.5 | Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөхөд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд | Улсын төсвөөр | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх ажлын талаар удирдах дээд байгууллагад санал хүргүүлсэн байх;<br>б/ Сүлжээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>в/ Бусад шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд төслийн саналын баримт бичиг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажилласан байх; | - Интернэтийн харилцан холболтын тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах<br>- Үндэсний дата төвийн нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх<br>- Үндэсний цахим шуудангийн дэд | Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх чиглэлээр холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна. | Жилд | Бүх нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах | | | бүтцийн тоног төхөөрөмж нийлүүлэх<br>- "ХУР" Төрийн мэдээлэл солилцооны системийг шинэчилж тархсан бүтцэд шилжүүлэх төслийн баримт бичгүүдийг хүргүүлсэн, тухай бүр мэдээлэл өгч, танилцуулга хийсэн. | | | |
| 1.4.6 | Төрийн зохиомол серверийн дэд бүтцийг өргөтгөх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төрийн зохиомол серверийн HCI дэд бүтэц болох vxRail бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;<br>б/ Тухайн дэд бүтцэд Cloud Native, Micro Service төрлийн системийн ажиллах орчин бүрдүүлэх;<br>в/ Зохиомол серверийн дэд бүтэц дээр "Vmware NSX" технологийг ашиглан сүлжээний аюулгүй байдлыг сайжруулсан байх; | Төрийн зохиомол серверийн HCI дэд бүтцэд төрийн 245 зохиомол сервер тус дэд бүтэц рүү шилжүүлэн байршуулж, төрийн зохиомол серверийн үйлчилгээг үзүүлж байна. | Төрийн зохиомол серверийн дэд бүтцэд HCI дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, "ХУР", "ДАН" "e-Mongolia" системүүдийн найдвартай, ажиллагааг хангах нөхцөл бүрдсэн байна. | Жилд | МТГ, МАБГ, ЗУГ /ТАУХ/ |
| 1.4.7 | Төрийн mCloud системийн дэд бүтцийг бий болгох | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Төрийн клауд суурь дэд бүтцийг бий болгож, сүлжээний архитектур зохион байгуулах;<br>б/ Төрийн клауд дэд бүтцийн тоног төхөөрөмжийн техникийн даалгаврыг боловсруулж, худалдан авалтыг хэрэгжүүлэх;<br>в/ Төрийн клауд дэд бүтцийг нэвтрүүлэх, сайжруулалт, төрийн байгууллагуудад сургалт хийх; | Төрийн зохиомол серверийн дэд бүтцэд 19 хост сервер дээр 438, 5 хост сервер дээр 230, 19 хост сервер 116 зохиомол серверийн үйлчилгээ үзүүлж байна. | IaaS болон PaaS түвшний клауд дэд бүтцийг ашиглалтад оруулж, төрийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна.<br>Төрийн клауд системийг ашиглах үйлчилгээний нөхцөл бүрдсэн байна.<br>Mindgolia-аас SaaS үйлчилгээ авах | 2 улиралд | МТГ, МАБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | г/ Төрийн клауд системийн үйлчилгээний нөхцөл боловсруулах;<br>д/ Mindgolia-тай уялдуулах; | | системийн орчин бүрдсэн байна. | | |
| 1.4.8 | Төвийн үйл ажиллагааны үйлчилгээний талаарх нэгдсэн мэдээллийг гаргах, тухай бүр шинэчлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төвийн үйл ажиллагаанд ашиглагдах, нэгдсэн мэдээллийн системийг ажиллагаанд оруулах;<br>б/Төвийн хэмжээний тоон мэдээллийг хяналтын нэгдсэн самбарыг бий болгох; | BI системийг тохируулж үйлчилгээний системүүдтэй, уялдуулж, мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлсэн. Төрийн цахим шуудан, цахим хуудас, зохиомол сервер, зогсуур түрээсийн мэдээллүүдийн самбаруудыг хийсэн. | BI нэгдсэн мэдээллийн системийг ашиглалтад бүрэн оруулсан байна. | Жилд | МТГ |

**ЗОРИЛТ 2. ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЙРШУУЛАХ, НЭГТГЭХ, ХАДГАЛАХ**

**Стратеги 1. Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, таатай нөхцөл бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, төсөл, санал боловсруулах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Төрийн их өгөгдлийн сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Үндэсний өгөгдлийн талаар баримтлах чиглэл боловсруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;<br>б/ Мета өгөгдлийн системийн үүсгэх шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, төсөл, санал боловсруулагдсан байна;<br>в/ Холбогдох байгууллагуудтай хамтран шийдлийг боловсруулж хүргүүлсэн байна; | ЦХХХЯ, ҮСХ хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус төвөөс оролцож ажиллаж байна. | Мета өгөгдлийн системийн үүсгэх шийдлийн судалгаа хийж, төрийн их өгөгдлийн сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгоход холбогдох байгууллагатай хамтран ажилласан байна. | 1 улиралд | МТГ /СНХ/ |

**Стратеги 2. Төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | Төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагааг хангах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Мэдээллийн сан бүхий төрийн байгууллагууд болон тэдгээрийн мэдээллийн сангийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна;<br>б/ Суурь мэдээллийн сангуудын хуулбар баазын ажиллагааг сайжруулах; | "E-Mongolia", "ХУР" системүүдийн суурь мэдээллийн сан бүхий зорилтот төрийн байгууллагуудын мэдээллийн санг байршуулж, төрийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох зорилтыг дэмжиж ажилласан. | E-Mogolia, ХУР системүүдийн суурь мэдээллийн сангуудын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, төрийн мэдээлэл солилцоог хөгжүүлэх зорилтыг дэмжиж ажилласан байна. | Жилд | МТГ /СНХ/ |
| 2.2.2 | Мэдээллийн сангуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төрийн байгууллагуудын мэдээллийн сангууд руу хандаж буй хэрэглэгчдийн эрхийн матриц гаргах, хэрэгжүүлэх;<br>б/ Мэдээллийн сангууд дээр хийгдэж буй үйлдлүүдийг бүртгэж авах аудит логуудыг илүү нарийвчилсан түвшинд хийх, сайжруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэх;<br>б/ Мэдээллийн сангуудын логуудыг нэгдсэн шинэ логийн системд холбох; | Төрийн суурь мэдээллийн сангууд, ХУР, ДАН системүүдийн мэдээллийн санг шинэ систем руу шилжүүлж ажиллагаанд оруулсан. | Хэрэглэгчийн эрхийн матриц гаргаж хэрэгжүүлэх, E-Mongolia, Улсын бүртгэлийн мэдээллийн сан, ХУР болон ДАН системүүдийн мэдээллийн сангуудын аудит логийн дүрмүүдийг шинэчилж, нэгдсэн лог сан бий болсон байна. | Жилд | МТГ, МАБГ |
| 2.2.3 | Мэдээллийн сангуудын хуулбар болон туршилтын орчны мэдээллийн сангуудыг бий болгох | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төвийн "Oracle Exadata" Мэдээллийн сан дээр байршиж буй төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудын хуулбар мэдээллийн сангуудыг бусад дэд бүтцүүд дээр үүсгэх;<br>б/ Шаардлагатай мэдээллийн сангууд дээр хөгжүүлэлт болон туршилтын | Шилэн дансны мэдээллийн сангийн хуулбарыг нөөц дэд бүтэц дээр ажиллах боломжийг бий болгосон. | E-Mongolia, ХУР системүүдийн суурь мэдээллийн сангуудын Real-Time хуулбарыг үүсгэж, тайлан, тоо статистик зэрэгт ашиглах боломжтой болсон байна. | Хагас жилд | МТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орчинд зориулсан хуулбар мэдээллийн сан бий болгох; | | | | |

**ЗОРИЛТ 3. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**

**Стратеги 1. Систем, сүлжээ болон орчны аюулгүй байдлыг хангах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Төвийн сүлжээ, систем болон түүний мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах шинэ техник, технологийн талаар судалгаа хийх | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Техник, технологийг судалсан байх /4 -өөс доошгүй төрлийн/;<br>б/ Судалгааны дүгнэлтэд тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх; | Төвийн аюулгүй байдлыг сайжруулахаар 2 төрлийн шинэ техник, технологийн судалгааг хийж, танилцуулсан | Төвийн сүлжээ, систем болон тэдгээрийн аюулгүй байдлыг сайжруулахад шаардлагатай технологийн судалгаа хийсэн байна. | Жилд | Бүх нэгж |
| 3.1.2 | Төвийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах ачаалал, ажиллагааны туршилтыг тогтмол зохион байгуулах | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Илэрсэн зөрчил, дутагдал, эрсдэлийг арилгасан байх;<br>б/ Системүүд дээр стресс тест хийх системийн судалгаа хийх нэвтрүүлэх боломжийг судлах;<br>в/ Нийт 2-оос доошгүй удаагийн туршилтыг гүйцэтгэсэн байх;<br>г/ Төвийн системүүдэд стресс тест болон найдвартай ажиллагааны туршилт хийх төлөвлөгөө гаргасан байх;<br>д/ Дэд бүтцийн техник төхөөрөмжүүдийн ашиглалтын туршилтыг гүйцэтгэсэн байх; | Тус төвийн систем, сүлжээ, дэд бүтцийн тоног төхөөрөмжид шаардлагатай ачааллыг зохиомлоор өгч туршин хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангаж ажилласан.<br>Төвийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжүүдийн ачаалал өндөр, үнээс шалтгаалан доголдол үүсэж байсан тул стресс тест хийх боломжгүй байсан. | Төвийн үйл ажиллагааны хэвийн, тасалдалгүй ажиллагааг хангасан байна. | Хагас жил тутам | МАБГ, МТГ /СНХ/, ЗУГ /ТАУХ, НТХ/ |
| 3.1.3 | Төвд байрлах төрийн | | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Тус төвд байрлах төрийн байгууллагуудын систем, цахим | Үндсэн болон дэмжих систем, ХХААХҮЯ, "И- | Нийт 10-аас доошгүй систем, цахим хуудаснуудад | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудын системд мэдээллийн аюулгүй байдлын шалгалт хийх | Дотоод нөөц | хуудсанд мэдээллийн аюулгүй байдлын шалгалт хийх;<br>б/ Мэдээллийн аюулгүй байдлын илэрсэн цоорхой, үр дүнг тухайн байгууллагуудад мэдээлж засварлуулах арга хэмжээ авах;<br>в/ Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах; | Монгол академи" УТҮГ зэрэг байгууллагын системүүд дээр аюулгүй байдлын шалгалтыг хийж тайланг хүргүүлж ажилласан. | мэдээллийн аюулгүй байдлын шалгалт хийж, холбогдох төрийн байгууллагад зөвлөмжийг хүргүүлж, шаардлага тавьж ажилласан байна. | Жилд | МАБГ |
| 3.1.4 | Төвийн ажилчдын цахим аюулгүй байдал, эцсийн төхөөрөмжүүдийн хяналтыг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Ажилчдыг албаны зөөврийн компьютероор хангах;<br>б/ Албаны зөөврийн компьютеруудад хамгаалалтын програм хангамжуудыг суулгаж аюулгүй байдлыг хангах; | Ажилчид хувийн компьютэроо албаны хэрэгцээнд ашиглаж байгаа нь аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй, мэдээлэл алдагдах боломжийг бүрдүүлж байна. Иймд нийт ажилчдад албаны зөөврийн компьютер авахаар худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан. | Нийт ажилчид хувийн зөөврийн компьютерыг албаны хэрэгцээнд ашиглахгүй болсон байна. Тус зөөврийн компьютеруудын аюулгүй байдал, хяналт бүрэн шийдэгдсэн байна. | Хагас жилд | МАБГ |
| 3.1.5 | Мэдээлэл, мэдээллийн системийн түвшин, ангиллыг тодорхойлох | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Мэдээллийг ангилах, түвшинд хуваах саналыг боловсруулж удирдах байгууллагад хүргүүлэх;<br>б/ Үндэсний дата төвд байршуулах мэдээллийн ангиллыг тодорхойлж саналыг боловсруулж хүргүүлэх;<br>В/ Хувийн хэвшлийн дата төв, гадны клауд серверт байрших мэдээлэл, мэдээллийн системийн ангиллын саналыг боловсруулж удирдах байгууллагад хүргүүлэх; | Төрийн байгууллагын бүх төрлийн мэдээлэл, мэдээллийн систем тус тэвд байрших боломжтой. Төрийн байгууллага ямар мэдээлэл, мэдээллийн системийг хувийн хэвшлийн дата төв, гадны клауд серверт байршуулж болох эсэх тодорхой ангилал, заавар байхгүй байна. | Үндэсний дата төвд байрших мэдээлэл, мэдээллийн систем болон хувийн хэвшлийн дата төв, гадны клауд серверт байрших мэдээлэл, мэдээллийн системийн ангиллын саналыг боловсруулж холбогдох | Жилд | МАБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагуудад хүргүүлсэн байна. | | |

**Стратеги 2. Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | Төрийн байгууллагуудын цахим шуудангийн системийн аюулгүй байдлыг дээшлүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төрийн байгууллагуудын цахим шуудангийн нууцлалт дээр 2FA баталгаажуулалтын хэрэглээг нэмэгдүүлэх дээр холбогдох байгууллагуудтай хамтран олон нийтэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож ажиллах;<br>б/ Цахим шуудангийн хамгаалалтын фаерволл дээр илэрсэн вирус, спамуудад дүн шинжилгээ хийж, хаах болон бусад холбогдох арга хэмжээг авч ажиллах; | Төрийн цахим шуудангийн системийг шинэчлэн нэвтэрсэн бөгөөд 2FA огт ашиглалтгүй. | Төрийн байгууллагуудын цахим шуудангийн системд 2FA баталгаажуулалтыг идэвхжүүлж, хэрэглээг нэмэгдүүлж ЦХХХЯ, МАБГ-тай хамтран олон нийтэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Жилд | МАБГ |
| 3.2.2 | Төрийн байгууллагуудын цахим хуудасны системийн аюулгүй байдлыг дээшлүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Цахим хуудасны хамгаалалтын төхөөрөмжийг суурилуулах, холбогдох тохиргоог хийж, бүрэн ажиллагаанд оруулах; | Цахим хуудасны аюулгүй байдлыг хангах програм хангамжийг худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан. | Цахим хуудаснуудын жагсаалтыг гарган, цахим хуудаснуудыг аюулгүй байдлын төхөөрөмжтэй холбсон байна. | 1-3 улиралд | МАБГ |
| 3.2.3 | Ажилчдын систем, сүлжээний төхөөрөмжүүд рүү хандах хандалтын хяналтыг сайжруулах, хязгаарлах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Хандалтын удирдлагын системийг нэвтрүүлэн, модулиудыг ашиглах;<br>Б/ Төв дээр ашиглагдаж буй систем, тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж, ангилан чухал систем, төхөөрөмжүүд тус системээр дамжин ханддаг байх; | Төв дээр ашиглагдаж буй хандалтыг удирдах систем нь лиценз сунгалт огт хийгдээгүй, шинэчлэлт байхгүй, ашиглалт багатай байна. | Хандалтын удирдлагын системийг нэвтрүүлэн, ашиглах бөгөөд төв дээр ашиглагдаж буй бүх систем, сүлжээний төхөөрөмжүүд тус системээр дамжин | 1-3 улиралд | МАБГ |

69

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | В/ Тус системээр дамжин хандаж буй хандалтууд дээр дүн шинжилгээ хийх; | | ханддаг болсон байна. | | |
| 3.2.4 | Үндсэн болон дэмжих системийн аюулгүй байдлыг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Шинээр холбогдож буй байгууллагуудыг тус VPN серверт холбох;<br>б/ Хуучин VPN серверт холбогдсон байгууллагуудыг шилжүүлэх;<br>в/ "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системд холбогдсон байгууллагуудад сервис дуудах rate-limit тогтоох нөхцөлийг бүрдүүлсэн байх;<br>г/ Тоон гарын үсгийн дэд бүтцийг шинэчлэхтэй холбоотойгоор тоон гарын үсгийн дэд бүтцийн шийдэл судлах, танилцуулах; | "ХУР төрийн мэдээлэл солилцооны системийн VPN сүлжээг нээлттэй эхийн програм хангамж ашиглан зохион байгуулж, ашиглаж эхэлсэн. | Байгууллагуудын 90-ээс доошгүй хувь нь шинээр зохион байгуулсан VPN серверт шилжсэн байна.<br>"ХУР" төрийн мэдээлэл солилцооны системд холбогдсон байгууллагууд системд хэт ачаалал үүсгэхээс сэргийлэн Rate-Limit ашиглан хязгаарлалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Жилд | МАБГ, МТГ /СНХ/ |

**Стратеги 3. Халдлагад хариу үйлдэл үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.1 | Төвийн үйлчилгээний найдвартай, тасралтгүй байдлыг хянах, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Мониторингийн нэгдсэн систем, лог бүртгэл, дүн шинжилгээ хийх програм хангамж, түүний модулиудыг нэвтрүүлсэн байх;<br>б/ Төвийн хэмжээнд хянах, мэдээлэх шаардлага бүхий системүүдийг уг системд бүрэн хамруулсан байх;<br>в/ ХУР, ДАН, ТҮЦ машины системийн ажиллагааг хяналтын системд бүрэн оруулсан байх; | Монгол улсын засгийн газрын mongolia.gov.mn, shilendans.gov.mn, e-mongolia.mn, president.mn, burtgel.gov.mn системүүдийг байршуулсан. | Лог бүртгэл, дүн шинжилгээний програм хангамжийн бүрэн нэвтрүүлж, төвд ашиглагдаж буй чухал систем, сүлжээний төхөөрөмжүүдийн жагсаалтыг дагуу хамруулсан байна. | Жилд | МАБГ, МТГ /СНХ/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.2 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.2-ийн хэрэгжилтийг хангаж Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Халдлага, зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлэх зааварчилгааг боловсруулах;<br>б/ Халдлага, зөрчил илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах<br>в/ "Bug Bounty" системийг хөгжүүлж дуусcан байх; | Системийн хэрэглэгчийн UI/UX загвар, өгөгдлийн сангийн зохион байгуулалтыг гаргасан. | Аливаа халдлага, зөрчил тохиолдсон үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан, дагаж мөрдөх үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Жилд | МАБГ, МТГ /СНХ/ |
| 3.3.3 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.5, 19.2.6-ийн хэрэгжилтийг хангаж кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлыг аудит хийлгэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хуульд заасан байгууллагаар хийлгэж гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;<br>б/ Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хийлгэх; | | Эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Жилд | МАБГ |

**ЗОРИЛТ 4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ**

**Стратеги 1. Төрийн мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Төрийн болон хувийн байгууллагуудад үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ | Дотоод нөөц | **Тоо: 2**<br>**Чанар:** а/ "ХУР" Төрийн мэдээлэл солилцооны систем, Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем, Мэдэгдэл хүргэх системийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br>б/ ЦХХХЯ-тай хийсэн гэрээг үндэслэн төрийн болон хувийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан байх; | "ХУР" Төрийн мэдээлэл солилцооны системд нийт 368 хувийн болон төрийн байгууллагууд холбогдсон.<br>Танилт, нэвтрэлтийн системд төрийн 45 байгууллагын 90 систем, хувийн хэвшлийн 111 | Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гэрээг үндэслэн тус төвийн үйлчилгээ үзүүлэх журмын хүрээнд шийдвэрлэн ажилласан байна. | Жилд | МТГ /СНХ/, МАБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | в/ Төр, хувийн хэвшлийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл солилцооны систем, танилт нэвтрэлтийн системд холбогдох хүсэлтийг автоматаар шийдвэрлэдэг болсон байх;<br>г/ Ургийн бичиг, тэрбум мод апп-уудыг хөгжүүлж, ХУР системд холбогдоход дэмжлэг үзүүлж ажиллах; | байгууллагын 126 систем холбогдсон байна. | Ургийн бичгийн udam.mn цахим системд холбогдох сервисүүдийг холбосон байна. | | |
| 4.1.2 | Танилт, нэвтрэлтийн системийг шинэчлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Гадаад иргэдийг таньж, баталгаажуулах боломжийг бүрдүүлэх;<br>б/ Хэрэглэгчдэд ээлтэй хэрэглэхэд хялбар ойлгомжтой "UI/UX" нэвтрүүлсэн байх;<br>в/ Олон хэлний сонголттой болгох; /Англи, Монгол, Кирилл/<br>г/ Байгууллагын хэрэглэгчийн нэвтрэлтийг бий болгох;<br>д/ Системийн архитектур зохион байгуулалтыг "Kubernetes" технологи ашиглан зохион байгуулсан байх; | Танилт, нэвтрэлтийн системийн архитектурыг "swarm cluster" бүтэцтэйгээр ажиллагаанд оруулсан. "Лайм" операторыг холбож гадаад улсад суугаа иргэдийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлсэн. Танилт, нэвтрэлтийн системд хэрэглэгчээс нэг удаагийн кодыг 130092 тусгай дугаарт илгээн баталгаажуулах хөгжүүлэлтийг хийсэн. | Танилт, нэвтрэлтийн системд шинэчлэлтүүдийг хийж, аюулгүй байдлын шаардлага хангасан шинэ холболт хийж, нэвтрэх боломжийг нэмэгдүүлсэн байна. | Жилд | МТГ /СНХ/ |
| 4.1.3 | Байгууллагын үйлчилгээ үзүүлэх системийг автоматжуулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ "ХУР, ДАН системд хэрэглэгч холбох үеийн ажиллагааг автоматжуулах;<br>а/ "Дотоод үйл ажиллагааны нэгдсэн "Дашбоард" системийг сайжруулах;<br>б/ Төвийн цахим хуудсанд цахимаар авч болох үйлчилгээнүүдийг холбосон байх; | Үндэсний дата төвийн мониторингийн дашбоардыг шинэчлэх, доголдол бүртгэх зориулалт бүхий шинэ "dashboard.gov.mn" системийг callcenter, доголдол бүртгэл, бусад хяналтын модулиудын хамтаар хөгжүүлсэн. | Хэрэглэгчийн үйлчилгээний системийн төлбөр тооцоог автоматжуулсан байна. | Жилд | МТГ /СНХ/, МАБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | в/ Онлайнаар төрийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх боломжийг бүрдүүлсэн байх;<br>д/ Гэрээг тоон гарын үсэг ашиглан цахимаар хийдэг байх; | | | | |

**Стратеги 2. Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1 | Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Байгууллагын үйлчилгээний журмын хүрээнд төрийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн байх;<br>б/ Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах, үйлчилгээг сайжруулах<br>в/ Үйлчилгээний системийг автоматжуулсан байх;<br>г/ Төвийн үйлчилгээний журамд тусгагдсан үйлчилгээг бүртгэлийн програмд бүрэн оруулсан байх; | Цахим хуудас, Цахим шуудан, Зохиомол сервер, зогсуур түрээс, Интернэтийн харилцан холболтын үйлчилгээнүүдийн хэвийн ажиллагааг хангах үйлчилгээ үзүүлсэн. IaaS түвшний туршилтын клауд системийг нэвтрүүлэн ажилласан. | Төрийн зохиомол серверийн үйлчилгээг IaaS болон PaaS түвшний клауд систем рүү шилжүүлсэн, Цахим хуудас байршуулах үйлчилгээний шинэ шийдлийг нэвтрүүлэн ажилласан байна. | Жилд | Бүх нэгж |
| 4.2.2 | Үндэсний цахим шуудангийн системийн, дэд бүтцийг сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Үндэсний цахим шуудангийн системийн сайжруулалтыг хийх;<br>б/ Үндэсний цахим шуудангийн системд лог ротэйт тохируулсан байх;<br>в/ Үндэсний цахим шуудангийн тусдаа бие даасан дэд бүтцийг бий болгох; | Үндэсний цахим шуудангийн систем нь 1086135 хэрэглэгчтэй иргэн бүр цахим шуудангийн хаягтай болох нөхцөл бүрдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлээд байна. | Бие даасан системийн бүтцийг бий болгосон байна.<br>Үндэсний цахим шуудангийн системийн мэдээллийн аюулгүй байдал болон системийн ажиллагаа, ашиглалт сайжирсан байна. | Хагас жилд | МТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3 | Ачааллын тест хийх үйлчилгээ нэвтрүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Төрийн байгууллагын системүүдэд туршилт хийх системийн дэд бүтцийг бэлтгэх;<br>б/ Үйлчилгээний нөхцөл, журам боловсруулах; | | Төрийн байгууллагуудаас нэвтрүүлж буй системүүдэд ачааллын тест хийн тухайн системийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах нөхцөл бүрдэнэ. | Жилд | МТГ |

**Стратеги 3. Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу мэдээллийн үйлчилгээгээр хангах;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.1 | Цахим хэлбэрт шилжих боломжтой төрийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан байх;<br>б/ Боломжит төрийн үйлчилгээг нэн тэргүүнд хамруулсан байх; | Биелэлтийн хугацаанд ХУР төрийн мэдээлэл солилцооны системд 29 байгууллагын 284 сервис нэмж хөгжүүлсэн. | Цахим хэлбэрт шилжих боломжтой төрийн үйлчилгээг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажилласан байна. | Жилд | МАБГ, МТГ |
| 4.3.2 | Төрийн үйлчилгээний цахим машины хэвийн ажиллагааг хангах, шинээр төрийн байгууллагуудын үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэлт хийх | Дотоод нөөц | **Тоо:** 2<br>**Чанар:** а/ Удирдах дээд байгууллагаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд үйлчилгээ нэмүүлэх хүсэлт гаргасан байгууллагуудын хүсэлтийг харгалзаж үзсэн байх;<br>б/ ТҮЦ машины үйлчилгээнд шинээр үйлчилгээ оруулах, нэмэлт хөгжүүлэлт хийх;<br>в/ Киоскуудыг шинэ шатанд гаргах шинэчилсэн байршлыг тодорхойлох тоон гарын үсэг олгодог болох; | Төрийн үйлчилгээний цахим машинд нийт 34 үйлчилгээ нэгтгэгдсэн бөгөөд 2022 онд 5 үйлчилгээ шинээр нэмэгдсэн.<br>Хувийн хэвшлийн киоск машинд ТҮЦ машины сервисийг нээлттэй болгох чиглэл авч ажиллаж байна. | Төрийн үйлчилгээний цахим машинаар үзүүлэх үйлчилгээний хүрээг нэмэгдүүлж, клауд болон иргэний үнэмлэх дээр тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, хувийн хэвшлийн машинуудаар олгоход дэмжлэг үзүүлж ажилласан байна. | Жилд | ЗУГ, МТГ /СНХ/ |

**Стратеги 4. Монголын дотоодын интернэтийн харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4.1 | Монголын дотоодын интернэтийн харилцан холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Layer2 технологи руу шилжүүлэх; IPv6 протоколоор дотоодын интернэт үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай холбогдсон байх;<br>б/ Интернэтийн харилцан холболтын нөөц төхөөрөмж бий болсон байх;<br>в/ Интернэтийн харилцан холболтын үйлчилгээнд холбогдох байгууллагуудын хүсэлтийн дагуу шаардлага хангасан байгууллагуудыг холбох; | Төвийн хувийн хэвшлийн интернэт хандалтын бүсэд IPv6-гийн туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөнд оруулсан.<br>2022 оны байдлаар 40 байгууллага холбогдон ажиллаж дунджаар 17.59Гб трафик дамжсан байна. | Интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг Layer2 болгож IPv6 технологи нэвтрүүлэх нөхцөлийг хангасан байна. | Жилд | МТГ |

**Стратеги 5. Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх;**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5.1 | Үйлчилгээнд ашиглагдах системийн mirror болон registry хадгалах систем бий болгох | Дотоод нөөц | **Тоо:** 1<br>**Чанар:** а/ Толин серверийн статистик мэдээллийг улирал нэг удаа танилцуулж байх;<br>б/ Линукс үйлдлийн системүүдийн толин серверийг системийн ажиллагааг хянаж ажиллах;<br>в/ "Docker image" байршуулах сервер бий болгох; | Толин сервер "Centos", "Ubuntu" үйлдлийн системүүдийн шинэчлэлийг тогтмол байршуулж хэвийн ажиллагааг хангаж ажилласан. | Толин серверийн үйлчилгээг улсын хэмжээнд хэвийн найдвартай үйлчилгээг үзүүлсэн байна.<br>Төрийн клауд үйлчилгээнд зориулсан "Docker image" байршуулах систем бий болсон байна. | Жилд | МТГ |

85

*Төлөвлөгөөний товчоон:*

| Зорилт | Стратеги | Ажил |
|---|---|---|
| | НИЙТ | **57** |
| ЗОРИЛТ 1: БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ, СУУРЬ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ | | **31** |
| Стратеги 1 | Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх | 11 |
| Стратеги 2 | Хамтын ажиллагааг хөгжүүлэх | 7 |
| Стратеги 3 | Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах | 5 |
| Стратеги 4 | Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах | 8 |
| ЗОРИЛТ 2. ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЙРШУУЛАХ, НЭГТГЭХ, ХАДГАЛАХ | | **4** |
| Стратеги 1. | Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, таатай нөхцөл бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, төсөл, санал боловсруулах | 1 |
| Стратеги 2. | Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах | 3 |
| ЗОРИЛТ 3. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ | | **12** |
| Стратеги 1 | Систем, сүлжээ болон орчны аюулгүй байдлыг хангах | 5 |
| Стратеги 2 | Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах | 4 |
| Стратеги 3 | . Халдлагад хариу үйлдэл үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх | 3 |
| ЗОРИЛТ 4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ | | **10** |
| Стратеги 1 | Төрийн мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх | 3 |
| Стратеги 2 | Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх | 3 |
| Стратеги 3 | Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу мэдээллийн үйлчилгээгээр хангах | 2 |
| Стратеги 4 | Монголын интернэтийн харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх | 1 |
| Стратеги 5 | Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх | 1 |

____________ o O o ____________